



СЭЛЭНГЭ АЙМАГ  
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/44

Сант сум

Өрхийн мэдээллийн судалгаа зохион  
байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг зохион байгуулах тухай” А/36 дугаар тушаал болон Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16-А/04 тоот хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын хэмжээнд “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлал”-аар нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн мэдээллийг шинэчлэх, мэдээлэл цуглуулах, удирдлага зохион байгуулалтаар хангах, судалгаанд ажиллах тоологч, хөтөч, жолоочийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах, ажлын төлөвлөгөө, удирдамж, чиг үүргийн хуваарь чиглэл зэргийг гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнх-Эрдэнэ

(Сумын Засаг даргын орлогч)

Гишүүд:

Л.Сэлэнгэсайхан

(Ивэн багийн Засаг дарга)

Б.Золбаяр

(Хушаат багийн Засаг дарга)

Ж.Оюунбат

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Наранцэцэг

(Хөдөлмөр, халамжийн асуудал)

Боловсруулсан: *Г. Наранцэнэ*  
Хянасан: *Ч. Агмарал*  
Хувь: *d*

хариуцсан мэргэжилтэн)

2.Судалгааг 2023 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн үр дүнтэй зохион байгуулж аргачлал, зааврын дагуу чанартай хийж гүйцэтгэн ажлын хэсгийн хийсэн ажлын тайланг судалгааны ажил дууссанаас хойш 7 хоногт багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнх-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР